



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
ГАЗАРЗҮЙН ТЭНХИМ

Газарзүйн Асуудлууд

Geographical Issues

Volume 23 (02)

ISSN: 2312-8534

2023

Улаанбаатар хот

Завхан аймгийн хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөн ба татах, түлхэх хүчин зүйлс

Population growth and migration of Zavkhan province and pull and push factors

©Цэдэв-Иш Отгонхүү^{1,2*}, Мягмарсүрэн Алтанбагана¹
Otgonghuu Tsedev-Ish^{1,2*}, Altanbagana Myagmarsuren¹

¹Шинжлэх Ухааны Академи, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбар, 14190, Улаанбаатар, Монгол Улс

²Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Газарзүйн тэнхимийн докторант, Улаанбаатар, Монгол Улс

¹Division of Social and Economic Geography, Institute Geography and Geoecology, Mongolian Academy of Sciences, 14190, Ulaanbaatar, Mongolia

²Department of Geography, School of Art and Science, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

*Харилцагч зохиогч: otgonghuuts@mas.ac.mn

*Corresponding author: otgonghuuts@mas.ac.mn

Хүлээн авсан: 2023.11.24

Засварласан: 2024.01.10

Зөвшөөрөгдсөн: 2024.01.11

Хураангуй: Монгол улсын Засгийн газраас Улаанбаатар хотыг чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөний эрчмийг бууруулах, төвлөрлийг сааруулах, аймаг, орон нутагт шилжин суурьшигчдыг дэмжих зорилтуудыг Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлэн ажиллаж байгаа энэ үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, ялангуяа аймаг, орон нутгийн түвшинд хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, унэлэлт, дүгнэлт өгөх, улмаар татах, түлхэх хүчин зүйлсийг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгааны үр дүнгээс харахад сүүлийн 30 жилийн дүнгээр Завхан аймгаас 78.1 мянган хүн шилжин явж, эдгээрийн 58.4 хувь буюу 45.6 мянган хүн Улаанбаатар хот руу шилжин ирж, хүн амын төвлөрдө хувь нэмрээ оруулжээ. Түүнчлэн сумдын түвшинд авч үзвэл тус хугацаанд Завхан аймгийн бүх сумдад хүн амын шилжин явалт давамгайлсан бөгөөд Улиастай сум (-16.8 мян.хүн), Тосонцэнгэл сум (-11 мян.хүн), Алдархаан сум (-4.6 мян.хүн)-аар тэргүүлжээ. Шилжих хөдөлгөөний үр дүнд тус аймгийн хүн амын тоо 1990-2020 онд 15.7 мянгаар буурсан бөгөөд 2хон суманд хүн ам өсч, бусад сумдад буурсан байна. Түүнчлэн сүүлийн 30 жилийн Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд аймаг, сумдын түвшинд дүн шинжилгээ хийж, шилжих хөдөлгөөний татах, түлхэх 15 хүчин зүйлсийг суурьшлын хэлбэрүүдээр тодорхойлон, ерөнхий боловсролын үйлчилгээний салбарт Завхан аймгийн жишээгээр дүн шинжилгээ хийлээ. Цаашид Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлс тус бүрээр дүн шинжилгээ хийж, газарзүйн шинжлэх ухааны үүднээс цогц байдлаар гүнзгийрүүлэн судлах нь чухал ач холбогдолтой байна.

Түлхүүр үгс: Хүн амын тоо, өсөлт, шилжих хөдөлгөөн, нутагшилт, суурьшил, татах, түлхэх хүчин зүйлс, Завхан аймаг

Abstract: The Government of Mongolia has set goals for reducing the intensity of population migration towards Ulaanbaatar, decentralization, and supporting return migration to provinces and rural areas in documents such as Vision 2050, New Revival Policy, and Mongolia's 5-Year Development Plan. It is necessary to scientifically study the geographical problems of internal population migration, especially at the provincial and local levels, to analyze the main indicators of population migration, to identify pull and push factors by settlement types, and to propose methods to support return migration. Therefore, the main purpose of this research is to analyze the main indicators of the internal population migration of the Zavkhan Province in the last 30 years, to give an assessment and conclusion, and then to determine and analyze the pull and push factors. According to the research results, during the last three decades, 78.1 thousand people migrated from Zavkhan province, 58.4 percent of them, or 45.6 thousand people migrated to Ulaanbaatar city, contributing to the population concentration. In addition, considering the soum

©Зохиогчийн оруулсан хувь нэмэр: **Ц.Отгонхүү:** Онолын үндэслэл, аргазүй боловсруулалт, өгөгдөл боловсруулалт, үндсэн бичвэр, **М.Алтанбагана:** Бичвэрийн үндсэн засвар, Үр дүнгийн хяналт хийсэн.

2312-8534/©2023 Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан.

level, population outmigration prevailed in all soums of Zavkhan province during this period, Uliastai soum (-16.8 thousand people), Tosontsengel soum (-11 thousand people) and Aldarkhaan soum (-4.6 thousand people) took the lead. As a result of migration, the population of the province decreased by 15.7 thousand persons from 1990-2020, and the population decreased in 22 soums. In addition, the main indicators of the internal population migration of Mongolia in the past 30 years were analyzed at the provinces and soum level, 15 pull and push factors of migration were determined by settlement types, and the general education service sector was analyzed using the example of Zavkhan province. In the future, it is important to analyze each of the pull and push factors of the internal population migration of the Mongolia and conduct a comprehensive and in-depth study from the point of view of geography.

Keywords: Population, growth, migration, settlement, pull and push factors, Zavkhan province

Оршил

Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хөдөө, орон нутагт бий болсон ажлын байрны хомсдол болон байгалийн гамшигт үзэгдлээс (ган, зуд) болж, амьжиргааны хэдэн малаа алдаж амьдрах аргагүй болсон малчдын хөдөөнөөс хот суурин газар руу чиглэсэн “Их нүүдэл” тасралтгүй үргэлжилсээр байна (Базаргүр, 2007). Эдгээр шилжин ирэгчид манай орны төв хэсэгт буюу томоохон хот суурин, тэдгээрийн дагуул бүс нутгуудаар суурьшиж, хүн амын байршил, нутагшилтад өөрчлөлт оруулж, хотын бүс нутгийн ачааллыг ихэсгэх, хүн амын хэт төвлөрөл, орчны бохирдол, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн зохисгүй харьцаа, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдал зэрэг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлст бодитойгоор нөлөөлөх боллоо (Энх-Амгалан нар, 2021). Үүний үр дүнд 2020 оны байдлаар хотын хүн амын тоо 2212.9 мянгад хүрч, хотжилтын түвшин 68.0 хувьтай байгаа нь 1990 онтой харьцуулахад хотын хүн амын тоо 1037.5 мянган хүн буюу 88.2 хувиар, хотжилтын түвшин 13.5 пунктээр тус тус өссөн байна (ҮСГ, 2021). Энэхүү хандлагыг ҮСХ-оос 2015 онд гаргасан Монгол Улсын хүн амын 2045 он хүртэлх хэтийн тооцоонд суурилан тооцож үзэхэд 2045 гэхэд Монгол Улсын нийт хүн амын тоо 5010.4 мянга, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 2868.7 мянга буюу нийт хүн амын 57.2 хувь болж, эрчимтэй нэмэгдэх зүй тогтолтой байна (Алтанбагана нар, 2022)

Хүн амын шилжих хөдөлгөөн нь улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, соёл, боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн амьжиргааны түвшин, нийгмийн халамж, хамгаалал, хот төлөвлөлт зэрэг бүхий л асуудалд эерэг, сөрөг үр дагавруудыг үзүүлж байдаг хүн амын газарзүйн хамгийн чухал судлагдахууны нэг (Батцэнгэл нар, 2021). Монгол улсын төрөөс иргэдийнхээ эх орныхоо өргөн уудам нутаг дэвсгэрийн хаана ч чөлөөтэй шилжих суурьших эрхийг хүндэтгэж, ажиллаж амьдрах газраа сонгох нөхцлийг бүрдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг аажмаар арилган жигдрүүлэх зорилгоор нийгэм, эдийн засгийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч дэд бүтэц, мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, ажиллаж амьдрах таатай орчинд татагдан, мэргэжил эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ илүү хүртээмжтэй төв суурин руу тэмүүлэх шилжих хөдөлгөөний урсгал буурахгүй хэвээр байна (ХАССТ, 2018). 1990-2021 оны нийт дүнгээр аймаг, орон нутгаас Улаанбаатар хотод нийтдээ 728.3 мян.хүн шилжин ирж, 197.9 мян.хүн шилжин явж, цэвэр шилжилт 530.4 мян.хүн болж байгаа бөгөөд 1990-2021 онуудын нийт шилжин ирэгчид 2021 оны Улаанбаатар хотын нийт хүн амын 47.3 хувьтай тэнцэж байна (Отгонхүү нар, 2022).

Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийн нэг нь хүн амын шилжих хөдөлгөөн бөгөөд Монгол улсын Засгийн газраас Улаанбаатар хотыг чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөний эрчмийг бууруулах, төвлөрлийг сааруулах, аймаг, орон нутагт шилжин суурьшигчдыг дэмжих зорилтуудыг Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлэн ажиллаж байгаа энэ үед хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, ялангуяа аймаг, орон нутгийн түвшинд хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, татах, түлхэх хүчин зүйлсийг суурьшлын хэлбэрээр тодорхойлж, буцах шилжих хөдөлгөөнийг дэмжих арга хэрэгслүүдийг дэвшүүлэх замаар Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг бууруулах судалгаа шаардлагатай байна. Сүүлийн 30 жилийн дүнгээр Завхан аймгаас 78.1 мянган хүн шилжин явж, 38.6 мянган хүн шилжин ирж, цэвэр шилжилт -39.5 мянга болж байгаа нь нийт 21 аймгаас Увс аймаг (-58.3 мян.хүн), Баян-Өлгий аймаг (-50.9 мян.хүн), Төв аймаг (-47.1 мян.хүн)-ийн дараа орох үзүүлэлт болж байна. Мөн энэ хугацаанд Завхан аймгаас Улаанбаатар хот руу шилжин явагчдыг тооцож үзвэл 45.6 мянган хүн болж байгаа нь Завхан аймгаас нийт шилжин явагчдын 58.4 хувь, Улаанбаатар хотод нийт шилжин ирэгчдийн 6.3 хувийг тус тус эзэлж,

Улаанбаатар хотын төвлөрөлд хувь нэмрээ оруулсаар байна (Отгонхүү нар, 2023). Тийм учраас Завхан аймгаар жишээ болгон хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, түүний нөлөөгөөр тус аймгийн хүн амын нутагшилт, суурьшилд гарсан өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийлээ.

Хүн амын шилжих хөдөлгөөнийг судлахдаа нэг газраас нөгөөд шилжин суурьших хүн амын хөдөлгөөнөөс гадна тэрхүү хөдөлгөөний шалтгаан, үзэгдлийн нөлөөгөөр нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлтийг бүхэлд нь багтаан авч үзэх шаардлагатай байдаг. Энэ утгаараа шилжих хөдөлгөөн нь эдийн засаг, социологи, төрийн захиргаа, эрхзүй, хүн ам зүй, нийгмийн газарзүй зэрэг нийгмийн олон шинжлэх ухаанд хамаарал бүхий салбар дундын судлагдахуун юм (Нарантулга, 2018). Энэ утгаараа Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөний асуудлыг нийгэм, эдийн засгийн газарзүйчид, хүн ам зүйчид, философичид, социологчид, статистикчид зэрэг олон мэргэжлийнхэн тал бүрээс нь судалсан байдаг. Тухайлбал: ШУА-ийн Газарзүйн хүрээлэн (хуучин нэрээр)-ийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын судлаачид 1960-аад оноос энэ асуудалд анхаарлаа хандуулж иржээ (Энх-Амгалан нар, 2012). Б.Гунгаадаш (1963, 1986), М.Баянтөр (1971, 1995), О.Сүхбаатар (1973), Ж.Оюунгэрэл (2005) тус тус нэг сэдэвт бүтээлүүд туурвижээ. Харин түүнээс хойш газарзүйн чиглэлээр хийгдсэн судалгаа орхигдож, томоохон бүтээл гараагүй байна. Энэхүү орон зайг нөхөж МУИС-ийн Хүн амын сургалт, судалгааны төвийн судлаачид 2000-аад оноос эхлэн цуврал судалгаануудыг (2001, 2004, 2009, 2018, 2021) олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр гүйцэтгэжээ. Түүнчлэн Үндэсний статистикийн газраас (2011, 2021) 2010 болон 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын материалд тулгуурлан Монгол улсын хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн илтгэлүүдийг гаргажээ. Хүн амын шилжих хөдөлгөөний чиглэлээр хувь судлаачид анхаарлаа хандуулж, Б.Нарантулга (2018) “Монголын нийгмийн шилжих хөдөлгөөн” бүтээл хэвлүүлжээ.

Гэвч эдгээр судалгаанууд нь Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нутаг дэвсгэрийн ялгааг нарийвчлан судлаагүй байна. Тийм учраас энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь сүүлийн 30 жилийн Завхан аймгийн хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, түүний нөлөөгөөр хүн амын нутагшилт, суурьшилд гарсан өөрчлөлтүүдийг тогтоож, улмаар татах, түлхэх хүчин зүйлсийг тодорхойлоход оршино. Түүнчлэн Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг, ялангуяа байгалийн гамшиг, ган, зуд ба хүн амын шилжих хөдөлгөөний хамаарлыг судалсан судалгаанууд сүүлийн жилүүдэд нэлээд хийгджээ. Тухайлбал: Монгол орны хөдөөгийн хүн ам, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргаа, түүний эмзэг байдал, дасан зохицох чиглэлээр (Sternberg, 2010; Gimenez et al., 2012, Nandintsetseg et al., 2017) зэрэг эрдэмтэд, тэдгээрт байгалийн гамшиг, ган, зудын нөлөөлөл, түүнчлэн түүнээс үүдсэн хүн амын шилжих хөдөлгөөний чиглэлээр (Ahearn, 2018; Schoening, 2020; Xu et al., 2021; Roekert, 2022) зэрэг эрдэмтэн, судлаачид судалгаа хийжээ. Харин энэхүү судалгаа нь Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд, түүний нөлөөгөөр хүн амын нутагшилт, суурьшилд гарсан өөрчлөлтүүдэд аймгийн түвшинд дүн шинжилгээ хийж, ерөнхий боловсролын үйлчилгээний жишээгээр тайлбарласнаараа чухал ач холбогдолтой.

Судалгааны материал, аргазүй

Энэхүү судалгаанд Завхан аймгийн хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг 1990-2020 оноор сумдын түвшинд цуглуулан дүн шинжилгээ хийсэн бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөн, байршил, нутагшилтын үндсэн үзүүлэлтүүдийн эх сурвалж нь Үндэсний статистикийн хорооноос 10 жил тутамд зохион байгуулдаг Хүн ам, орон сууцны тооллого болон суурин хүн амын жилийн эцсийн мэдээ, шилжин суурьшсан хүн амын тайлангууд юм. Шалгуур үзүүлэлтүүдийг Монгол улсын статистикийн эмхэтгэл болон (www.1212.mn) статистик мэдээллийн сангаас аймаг, сумдын түвшинд 1990-2000, 2000-2010, 2010-2020 онуудаар цуглуулан “MS Excel” программ дээр анхан шатны боловсруулалтуудыг хийж, мэдээллийн сан үүсгэж, “ArcGIS” программ дээр давхаргууд үүсгэж, сэдэвчилсэн зургууд зохиох замаар дүн шинжилгээ хийлээ.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь орон зай, цаг хугацааны хэмжээс бүхий, нийгэм, эдийн засаг, байгалийн нөхцөл, нөөцийн зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалах нийгэм, эдийн засгийн газарзүйн үйл явц бөгөөд түүний нутаг дэвсгэрийн онцлогийг илрүүлэхэд шилжин явагчид болон

ирэгчид, шилжих хөдөлгөөний эрчим гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг ашигладаг (Оюунгэрэл, 2005) бөгөөд доорх томъёонуудаар тооцдог (ХАССТ, 2006).

$$\text{ШХЭ} = \frac{\text{ШИ} + \text{ШЯ}}{\text{ХА}} * 1000 \quad (1) \quad \text{ШИК} = \frac{\text{ШИ}}{\text{ХА}} * 1000 \quad (2) \quad \text{ШЯК} = \frac{\text{ШЯ}}{\text{ХА}} * 1000 \quad (1)$$

ШХЭ – Шилжих хөдөлгөөний эрчим

ШИ – Шилжин ирсэн хүн амын тоо

ШЯ – Шилжин явсан хүн амын тоо

ХА – Хүн амын жилийн дундаж тоо

ШИК – Шилжин ирэлтийн

коэффициент

ШИ – Шилжин ирсэн хүн амын тоо

ХА – Хүн амын жилийн дундаж тоо

ШЯК – Шилжин явалтын

коэффициент

ШЯ – Шилжин явсан хүн амын тоо

Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэх бөгөөд хүн амын өөрчлөлтийн газарзүйн ялгааг тодорхойлохдоо засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд (сум, баг) хүн амын жилийн дундаж өсөлтийн хувиар (ЖДӨХ) тооцдог. ЖДӨХ-ийг дараах томъёогоор тооцно (ҮСГ, 2013).

$$\text{ЖДӨХ} = \frac{\text{ХА}(т) - \text{ХА}(с)}{\text{Х} * \text{ХА}(с)} * 100 \quad (2)$$

ЖДӨХ – Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь

ХА(т) – Тайлант оны хүн амын тоо

ХА(с) – Суурь оны хүн амын тоо

Х – Суурь болон тайлант оны хоорондох хугацаа

Хүн амын өөрчлөлтөд шилжих хөдөлгөөний нөлөөллийг тооцохын тулд тухайн сум, орон нутгийн хүн амын ЖДӨХ-ийг Монгол Улсын нийт хүн амын ЖДӨХ-тай харьцуулан дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Буурсан (Хүн амын ЖДӨХ < 0 бол хүн амын тоо буурсан)
2. Хэвийн өссөн (Хүн амын ЖДӨХ < Улсын хүн амын ЖДӨХ бол хүн амын тоо хэвийн өссөн)
3. Механик өссөн (Хүн амын ЖДӨХ > Улсын хүн амын ЖДӨХ бол хүн амын тоо механик өссөн) гэж үзсэн.

Завхан аймгийн сумдын түвшинд хүн амын тооны өөрчлөлтөд шилжих хөдөлгөөний нөлөөллийг тодорхойлохын тулд шилжин ирэгчид болон явагчдын тоог 1990-2020 оноор, сумдын түвшинд цуглуулсан байх шаардлагатай боловч энэхүү мэдээ бүрдэхгүй байсан тул хүн амын шилжих хөдөлгөөний цэвэр шилжилтийг 1990-2020 оноор сумдын түвшинд тооцлоо. Дотоод шилжих хөдөлгөөний талаарх тоон мэдээлэл дутагдалтай үед шууд бус аргаар цэвэр шилжилтийг тооцдог бөгөөд шууд бусаар тооцох үндсэн хоёр арга бий. Үүнд:

- Хүн ам зүйн тэнцлийн томъёо ашиглах арга
- Хүн амын өсөлтийн түвшинд суурилах арга

Энэхүү судалгаанд хүн амын өсөлтийн түвшинд суурилах аргыг ашигласан бөгөөд энэ арга нь хугацааны эхний болон эцсийн хүн амын мэдээллийг ашиглан хоёр хугацааны хоорондох цэвэр шилжилтийг тооцдог. Ингэхдээ тухайн орон нутгийн хүн амын өсөлтийн түвшин нь улсын дундаж түвшингээс илүү тохиолдолд тухайн орон нутагт шилжин ирэлт давамгайлсан, эсрэг тохиолдолд тус орон нутагт цэвэр шилжилт хасах утгатай гарч шилжин явалт нь шилжин ирэлтээс өндөр байсныг илэрхийлнэ (Нарантулга, 2018).

$$\text{ЦШ}(o-t)a = [(\text{ХА}(t)a - \text{ХА}(o)a) / \text{ХА}(o)a - (\text{ХА}(t) - \text{ХА}(o)) / \text{ХА}(o)] * \text{ХА}(o)a \quad (3)$$

Энд, $\text{ЦШ}(o-t)a$ - $o-t$ хугацаан дахь a орон нутгийн цэвэр шилжилт, $\text{ХА}(t)a$ - Хугацааны эцэс дэхь a орон нутгийн хүн амын тоо, $\text{ХА}(o)a$ - Хугацааны эхэн дэхь a орон нутгийн хүн амын тоо, $\text{ХА}t$ - Хугацааны эцэс дэхь улсын нийт хүн амын тоо, $\text{ХА}o$ - Хугацааны эхэн дэхь улсын нийт хүн амын тоо

Судалгааны үр дүн

Завхан аймгийн хүн амын шилжих хөдөлгөөн: Ардчилал, зах зээлийн харилцаанд шилжин орсноос хойших үед улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд хүчтэй өөрчлөлт орсноор хүн ам зүйн томоохон өөрчлөлтүүд гарсан билээ. 1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулиар Монгол Улсын иргэн оршин суух газраа өөрсдөө сонгох эрхтэй болсноор хатуу хараа хяналттай шилжин суудаг байсан иргэд чөлөөтэй, сайн дураар шилжин суурьших эрхтэй болсон (Монгол Улсын

үндсэн хууль, 1992). 1991-1992 онд хөдөөд нэгдэл, сангийн аж ахуйн өмч хувьчлал явагдаж, түүнээс хувь хүртэх сонирхолтой, “шинэ цагийн малчид” хотоос хөдөө шилжин суурьшиж байсан нь шилжин явалт давамгайлахад хүргэсэн. Гэвч энэ нь түр зуурын “хуурамч” шилжилт байв (Оюунгэрэл, 2005). 1992 оноос хойш шилжин явалт бүх нутагт давамгайлж, 1999 оноос шилжин ирэлт, явалт тэнцвэржих хандлагатай болсон. Монгол Улсын дүнгээр нийт шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоог сүүлийн 30 жилийн хугацаанд авч үзэхэд жилд дунджаар 95.3 мянган хүн шилжих хөдөлгөөнд оролцдог боловч 2000, 2004, 2010 зэрэг онуудад хүн амын шилжих хөдөлгөөн эрчимжсэн ерөнхий хандлагатай байна (Отгонхүү нар, 2022).

Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний сүүлийн 30 жилийн хандлагаас харахад хөдөөнөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу шилжин суурьших үйл явц харьцангуй өндөр хэвээр байсаар байна (Alгаа, 2021). Тухайлбал: Сүүлийн 30 жилийн нийт дүнгээр Завхан аймгаас 78.1 мянган хүн шилжин явж (45.6 мянга нь Улаанбаатар луу), 38.6 мянган хүн шилжин ирж, цэвэр шилжилт -39.5 мянга болжээ.




Зураг 1. Завхан аймгийн хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүд (1990-2021)

Завхан аймгийн сумдын хүн амын цэвэр шилжилтийг 1990-2020 онуудаар хүн амын өсөлтийн түвшинд суурилах аргаар дүн шинжилгээ хийхэд 1990-2000 онд Завхан аймгийн Их-Уул сум (0.5 мян.хүн), Тэлмэн сум (0.1 мян.хүн), Ургамал сум (0.1 мян.хүн) зэрэг 6 суманд шилжин ирэлт давамгайлсан бол Улиастай сум (-8 мян.хүн), Тосонцэнгэл сум (-5.1 мян.хүн), Баянтэс сум (-1.5 мян.хүн) зэрэг 18 суманд шилжин явалт давамгайлжээ. Харин 2000-2010 он бол Монгол Улсын хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөний оргил үе бөгөөд Завхан аймгийн бүх сумдад шилжин явалт давамгайлсан байна. 2010-2020 онд Завхан аймгийн Дөрвөлжин сум (0.1 мян.хүн), Тосонцэнгэл сум (0.1 мян.хүн), Асгат сум (0.05 мян.хүн) зэрэг 3 суманд шилжин ирэлт давамгайлсан бол Улиастай сум (-0.9 мян.хүн), Отгон сум (-0.9 мян.хүн), Шилүүстэй сум (-0.5 мян.хүн) зэрэг 21 суманд шилжин явалт давамгайлжээ.

Хүснэгт 1. Завхан аймгийн хүн амын цэвэр шилжилт, сумдаар, 1990-2020

№	Хүн амын цэвэр шилжилт	1990-2000	2000-2010	2010-2020	1990-2020
1	Шилжин ирэлт давамгайлсан	6	0	3	0
2	Шилжин явалт давамгайлсан	18	24	21	24
2.1	2000 хүртэл	16	20	21	14
2.2	2000-аас дээш	2	4	0	10
3	Нийт	24	24	24	24

Сүүлийн 30 жилийн нийт дүнгээр Завхан аймгийн бүх сумдад хүн амын шилжин явалт давамгайлсан бөгөөд Улиастай сум (-16.8 мян.хүн), Тосонцэнгэл сум (-11 мян.хүн), Алдархаан сум (-4.6 мян.хүн)-аар тэргүүлжээ. Шилжин явалт давамгайлсан сумдыг цэвэр шилжилтээр нь ангилж үзвэл 10 суманд 2 000-аас дээш, 14 суманд 2000 хүртэл байна.



Зураг 2. Завхан аймгийн хүн амын цэвэр шилжилт, сумдаар (1990-2020)

Шилжих хөдөлгөөний нөлөөгөөр Завхан аймгийн хүн амын нутагишилт, суурьшилд гарсан өөрчлөлтүүд: Монгол улсын хүн амд Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол улсын харьяат хүн амыг хамруулдаг бөгөөд Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амд Монгол улсын засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно (ҮСГ, 2013). 2020 оны тооллогын дүнгээр Завхан аймгийн харьяат хүн ам 72.8 мянга, үүнээс аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам 72.3 мянга байна. Тус аймгийн хүн амын тоо 1990 оноос 15.7 мянгаар буурсан бол 2010 оноос жилд дундажаар 1.2 өссөн дүнтэй байна (Завхан аймгийн Статистикийн хэлтэс, 2021).

Завхан аймгийн сумдын хүн амын ЖДӨХ-ийг 1990-2020 онуудаар улсын дундажтай харьцуулан дүн шинжилгээ хийхэд 1990-2000 онд (1990-2000 онд Монгол Улсын хүн амын ЖДӨХ 1.6 хувь байв) Их-Уул сум (2.6%), Ургамал сум (2.2%), Тэлмэн сум (2.1%) зэрэг 6 суманд механик өссөн бол Отгон сум (1.5%), Цагаанхайрхан сум (1.3%), Нөмрөг сум (1%) зэрэг 7 суманд хэвийн өссөн байна. Харин Асгат сум (-3.9%), Баянтэс сум (-2.5%), Тосонцэнгэл сум (-2.3%) зэрэг 11 суманд буурсан байна. 2000-2010 онд Завхан аймгийн хүн амын ЖДӨХ-ийг улсын дундажтай (2000-2010 онд Монгол Улсын хүн амын ЖДӨХ 1.2 хувь байв) харьцуулан авч үзвэл бүх сумдад хүн амын тоо буурсан бөгөөд Ургамал сум (-4.5%), Эрдэнэхайрхан сум (-3.9%), Яруу сум (-3.8%) аар тэргүүлжээ. 2010-2020 онд энэхүү үзүүлэлтийг (улсын дундаж хүн амын ЖДӨХ 2.3%) авч үзвэл Дөрвөлжин сум (3.1%), Асгат сум (2.9%), Тосонцэнгэл сум (2.4%) зэрэг сумдад механик өссөн бол Их-Уул сум (2.1%), Эрдэнэхайрхан сум (2%), Ургамал сум (1.7%) зэрэг 17 суманд

хэвийн өсчээ. Харин Отгон сум (-0.9%), Шилүүстэй сум (-0.5%), Цэцэн-Уул сум (-0.1%) зэрэг 4 суманд буурсан байна.

Хүснэгт 2. Завхан аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, 1990-2020


№	Хүн амын тооны өөрчлөлт, сумдаар	1990-2000	2000-2010	2010-2020	1990-2020
1	Буурсан	11	24	4	22
2	Хэвийн өссөн	7	0	17	2
3	Механик өссөн	6	0	3	0
4	Нийт	24	24	24	24

1990-2020 оны дүнгээр Завхан аймгийн сумдын хүн амын ЖДӨХ-ийг улсын дундажтай (1990-2020 онд Монгол Улсын хүн амын ЖДӨХ 2.0 хувь байв (ҮСГ, 2021)) харьцуулан авч үзвэл зөвхөн Их-Уул сум (0.7%), Тэлмэн сум (0.1%) сумдад хэвийн өссөн бол Яруу сум (-1.9%), Цагаанхайрхан сум (-1.7%), Цагаанчулуут сум (-1.7%) зэрэг 22 суманд буурчээ. Энэхүү хүн амын тооны өөрчлөлтийн үр дүнд Завхан аймгийн сумдыг хүн амын тоогоор нь ангилж үзвэл 1990 онд маш жижиг сум байхгүй, жижиг сум 16, дунд сум 5, том сум 1, томоохон сум 2 байсан бол 2020 оны байдлаар маш жижиг сум 5, жижиг сум 15, дунд сум 1, том сум 2, томоохон сум 1 болжээ.

Хүснэгт 3. Завхан аймгийн сумдын тоо, хүн амын тооны ангиллаар, 1990-2020

№	Сумын хүн амын тоо	1990	2000	2010	2020
1	Маш жижиг (1500 хүртэл)	0	2	2	5
2	Жижиг (1501-3000)	16	13	19	15
3	Дунд (3001-5000)	5	6	1	1
4	Том (5001-10000)	1	2	1	2
	Томоохон (10001-ээс дээш)	2	1	1	1
	Нийт	24	24	24	24

Завхан аймгийн хүн амын ЖДӨХ-ийг улсын дундажтай харьцуулан 1995-2020 оноор суурьшлын хэлбэрээр (аймгийн төв, сумын төв, хөдөө) дүн шинжилгээ хийлээ. Аймгийн төв Улиастай хотын хүн амын тоо 1995-2000 онд жилд дундажаар 4.7%-аар, 2000-2010 онд 1.4%-аар тус тус буурсан бол 2010-2020 онд 0.4%-аар өссөн байна. Сүүлийн 25 жилийн дүнгээр тус хотын хүн амын тоо 7.4 мянган хүнээр буюу 31%-аар, ЖДӨХ (-1.2)% хувьтай байсан нь Монгол Улсад хүн амын тоо хамгийн ихээр буурсан аймгийн төвүүдийн нэг болжээ. Сумын төвүүдийн хувьд дүн шинжилгээ хийж үзэхэд 1995-2000 онд 20 сумын төв буурч, 1 сумын төв хэвийн өсч, 2 сумын төв хүн ам механик өсчээ. Харин 2000-2010 онд 20 сумын төв буурч, 3 сумын төвийн хүн ам механик өссөн байна. 2010-2020 онд 17 сумын төв буурч, 4 сумын төв хэвийн өссөн бол 2 сумын төв механик өссөн байна. Сүүлийн 25 жилийн дүнгээр Завхан аймгийн 21 сумын төвийн хүн ам буурч, зөвхөн 1 сумын төв (Их-Уул сум)-ийн хүн ам хэвийн өсч, 1 сумын төв (Баянтэс сум) механик өсчээ. Хөдөөгийн хүн амын хувьд дүн шинжилгээ хийж үзэхэд 1995-2000 онд 15 сум буурч, 3 сум хэвийн өсч, 5 сумын хөдөөгийн хүн ам механик өсчээ. Харин 2000-2010 онд 17 сум буурч, 1 сум хэвийн өсч, 5 сумын хөдөөгийн хүн ам механик өсчээ. Түүнчлэн 2010-2020 онд 10 сум буурч, 10 сум хэвийн өсч, 3 сумын хөдөөгийн хүн ам механик өсчээ. Сүүлийн 25 жилийн дүнгээр Завхан аймгийн 21 сумын хөдөөгийн хүн ам буурч, 2 сум хэвийн өссөн байна.



Зураг 3. Завхан аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, суурьшлын хэлбэрээр (1995-2020)

Хүснэгт 4. Завхан аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, суурьшлын хэлбэрээр (1995-2020)

Хүн амын жилийн тооны өөрчлөлт	1995-2000			2000-2010			2010-2020			1995-2020		
	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Буурсан	1	20	15	1	20	17	0	17	10	1	21	21
Хэвийн өссөн	0	1	3	0	0	1	1	4	10	0	1	2
Механик өссөн	0	2	5	0	3	5	0	2	3	0	1	0

Хэлэлцүүлэг


Хүний хөгжлийн үндсэн үзэл санаа нь хүмүүсийн эдийн засгийн, нийгмийн, улс төрийн болон соёлын гэх мэт сонголтуудыг өргөжүүлэх үйл явц, нөгөө талаас сонголт хийх өргөн боломжоор хангах явдал юм (Chuluun, Caffney, 2010). Эдгээр хүний хөгжлийн үзэл санааны сонголт, боломжууд нь Монгол Улсын иргэн орон зайн хувьд Улаанбаатар, аймгийн төвүүд, сумын төв, хөдөө хаана ч суурьшсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар

олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхээ бүрэн дүүрэн эдлэх таатай орчин нөхцөлийг нутаг дэвсгэр, орон зайн хувьд авч үзвэл үндсэндээ ганцхан цэгт бүх сонголт, боломж байна (Government of Mongolia, 2023). Эсрэгээрээ хөдөө орон нутаг, аймаг, сумдад хүн нийгэм, эдийн засгийн аятай, таатай орчинд ажиллаж, амьдрах сонголт, боломж хомс байгаа юм (Алтанбагана, 2023). Ийнхүү хүн амын шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлийн онолоор (Lee, 1966) хүн аятай, таатай нийгэм, эдийн засгийн нөхцөлд ажиллаж амьдрах бүх татах хүч нь зөвхөн Улаанбаатар хотод төвлөрсөн байна. Тухайлбал: Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын (2021) судалгаанд дурьдсанаар Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 38.5 хувь нь ажил хөдөлмөр, бизнес эрхлэх боломж хайн, 21 хувь нь амьдралын нөхцөл, амьжиргаагаа дээшлүүлэхээр, 20.2 хувь нь боловсролын үйлчилгээ авахаар, 6.4 хувь нь үр хүүхдийн ирээдүйн амьдралын төлөө, 5.1 хувь нь гэр бүлийн гишүүд, хамаатан саднаа бараадан, 3.1 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ авахаар, 5.7 хувь нь бусад шалтгаанаар шилжин иржээ.

Энэ хүрээнд бид сүүлийн 30 жилийн Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлтүүдэд аймаг, сумдын түвшинд дүн шинжилгээ хийж, шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлсийг суурьшлын хэлбэрүүдээр тодорхойлон, Улаанбаатар хотод хүн амыг төвлөрүүлж буй хүчин зүйлсийг задлах зорилгоор хүн амын шилжих хөдөлгөөний үндсэн хүчин зүйлсийн нэг болох боловсролын үйлчилгээний, ялангуяа ерөнхий боловсролын үйлчилгээний салбарт дүн шинжилгээ хийлээ. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний олон судалгаануудад чанартай боловсрол эзэмших нь Улаанбаатар хотод шилжин ирэх үндсэн шалтгааны нэг байдаг тухай дурьдсан байдаг бөгөөд дараах шалтгаануудын улмаас ерөнхий боловсролын үйлчилгээ нь Улаанбаатар хотод хүн амыг татах үндсэн хүчин зүйл болж байна. Үүнд:

1. Монгол Улсын ерөнхий боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн зохион байгуулалт алдагдсан.

Ерөнхий Боловсролын Сургууль (ЕБС) нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэнд дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бөгөөд эзэмшүүлэх боловсролын түвшинг харгалзан бага, дунд, ахлах сургууль гэж ангилдаг. Бага, дунд, ахлах сургууль нь цогцолбор хэлбэрээр хоршин ажиллаж болно (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002). Монгол Улсын нийт ЕБС-иудыг энэ ангиллаар ангилхад бага сургууль 8.6% нь буюу 74, 12.7% нь буюу 109 нь дунд сургууль, 73.3% нь буюу 630 нь ахлах сургууль, 5.4% нь буюу 46 нь цогцолбор сургууль байна (БШУЯ, 2023). Монгол Улсын ерөнхий боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн зохион байгуулалт нь ахлах сургуультай сумд нь тухайн бүс нутгийнхаа боловсролын үйлчилгээний төв болж, ойролцоох хэд хэдэн сумдын хүүхдүүдэд бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ЕБС-тай байхад тохиромжтой боловч энэ байдал алдагдсан байна. Тухайлбал: Завхан аймаг 24 сумтай бөгөөд Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Яруу сумдаас бусад 18 сум нь ЕБ-ын ахлах сургуультай байна. ЕБС-ийн бүлэг дүүргэлтийн стандарт 20-25 хүүхэдтэй байхаар тооцвол 300-аас цөөн сурагчтай буюу ЕБ-ын ахлах сургуультай байхад тохиромжгүй Асгат, Баянхайрхан, Завханмандал, Сантмаргац, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй зэрэг сумд байна.




Зураг 4. 2022-2023 оны хичээлийн жилийн Монгол Улсын ЕБС-ын ангилал

ЕБС нь ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай гэсэн хэв шинжтэй байх (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002) бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилийн дүнгээр Монгол Улсад 859 ЕБС үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ЕБС-ийг сургалтын хэв шинжээр нь ангилж үзвэл 87.6% нь буюу 753 нь ердийн, 2% нь буюу 17 нь төрөлжсөн, 8.1% нь буюу 70 нь гүнзгийрүүлсэн, 0.7% нь буюу 6 нь тусгай, 1.5% нь буюу 13 нь олон улсын хөтөлбөртэй байна (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002). Харин ЕБС-ийн сургалтын ангиллыг байршлаар авч үзвэл ердийн 30.1%, төрөлжсөн 41.2%, гүнзгийрүүлсэн 62.9%, тусгай 100%, олон улсын хөтөлбөртэй 92.3% нь тус тус Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Аймаг, орон нутагт гүнзгийрүүлсэн, тусгай болон олон улсын хөтөлбөртэй ЕБС хангалтгүй байна. Завхан аймгийн хувьд ЕБ-ын 30 сургуультай бөгөөд төрөлжсөн 1, гүнзгийрүүлсэн 2 сургууль нь зөвхөн аймгийн төв Улиастай хотод үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 5. Монгол Улсын ЕБС-ын сургалтын хэв шинж, 2022-2023 оны хичээлийн жил

№	Сургуулийн ангилал, сургалтын хэв шинжээр	Улаанбаатар		Аймаг, орон нутаг		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Ердийн	227	30.1	526	69.9	753	100.0
2	Төрөлжсөн	7	41.2	10	58.8	17	100.0
3	Гүнзгийрүүлсэн	44	62.9	26	37.1	70	100.0
4	Тусгай	6	100.0	0	0.0	6	100.0
5	Олон Улсын хөтөлбөртэй	12	92.3	1	7.7	13	100.0
6	Нийт	296	34.5	563	65.5	859	100.0



Зураг 5. 2022-2023 оны хичээлийн жилд Монгол Улсын ЕБС-ын сургалтын хэв шинж

Дүгнэлт

Сүүлийн 30 жилийн нийт дүнгээр Завхан аймгаас 78.1 мянган хүн шилжин явж (45.6 мянга нь Улаанбаатар луу), 38.6 мянган хүн шилжин ирж, цэвэр шилжилт -39.5 мянга болжээ. Энэ хугацаанд Завхан аймгийн бүх сумдад хүн амын шилжин явалт давамгайлсан бөгөөд Улиастай сум (-16.8 мян.хүн), Тосонцэнгэл сум (-11 мян.хүн), Алдархаан сум (-4.6 мян.хүн)-аар тэргүүлжээ. Шилжин явалт давамгайлсан сумдыг цэвэр шилжилтээр нь ангилж үзвэл 10 суманд 2 000-аас дээш, 14 суманд 2 000 хүртэл байна.

2020 оны тооллогын дүнгээр Завхан аймгийн харьяат хүн ам 72.8 мянга, үүнээс аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам 72.3 мянга байна. Тус аймгийн хүн амын тоо 1990 оноос 15.7 мянгаар буурсан бол 2010 оноос жилд дундажаар 1.2 өссөн дүнтэй байна. 1990-2020 оны дүнгээр Завхан аймгийн сумдын хүн амын ЖДӨХ-ийг улсын дундажтай харьцуулан авч үзвэл 2 суманд хэвийн өссөн бол 22 суманд буурчээ. Энэхүү хүн амын тооны өөрчлөлтийн үр дүнд Завхан аймгийн сумдыг хүн амын тоогоор нь ангилж үзвэл 1990 онд маш жижиг сум байхгүй, жижиг сум 16, дунд сум 5, том сум 1, томоохон сум 2 байсан бол 2020 оны байдлаар маш жижиг сум 5, жижиг сум 15, дунд сум 1, том сум 2, томоохон сум 1 болжээ.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаануудын нэг ерөнхий боловсролын үйлчилгээний жишээгээр Завхан аймгийн сумдын түвшинд дүн шинжилгээ хийлээ. Монгол Улсын ерөнхий боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн зохион байгуулалт нь ахлах сургуультай сумд нь тухайн бүс нутгийнхаа боловсролын үйлчилгээний төв болж, ойролцоох хэд хэдэн сумдын хүүхдүүдэд бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ЕБС-тай байхад тохиромжтой боловч энэ байдал алдагдсан байна. Тухайлбал: Завхан аймаг 24 сумтай бөгөөд Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Яруу сумдаас бусад 18 сум нь ЕБ-ын ахлах сургуультай байна. ЕБС-ийн бүлэг дүүргэлтийн стандарт 20-25 хүүхэдтэй байхаар тооцвол 300-аас цөөн сурагчтай буюу ЕБ-ын ахлах сургуультай байхад тохиромжгүй Асгат, Баянхайрхан, Завханмандал, Сантмаргац, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй зэрэг сумд байна. Түүнчлэн аймаг, орон нутагт гүнзгийрүүлсэн, тусгай болон олон улсын хөтөлбөртэй ЕБС хангалтгүй байна. Завхан аймгийн хувьд ЕБ-ын 30 сургуультай бөгөөд төрөлжсөн 1, гүнзгийрүүлсэн 2 сургууль нь зөвхөн аймгийн төв Улиастай хотод үйл ажиллагаа явуулж байна. Цаашид Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлс тус бүрээр дүн шинжилгээ хийж, газарзүйн шинжлэх ухааны үүднээс цогц байдлаар гүнзгийрүүлэн судлах нь чухал ач холбогдолтой байна.

Талархал

Энэхүү судалгаа нь БШУЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санхүүжилтээр Газарзүй, Геоэкологийн хүрээлэнд хэрэгжиж байгаа “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний орон зайн зүй тогтол, нөлөөлөх хүчин зүйлс (2022-2024)” суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн бөгөөд судалгааны ажилд үнэтэй зөвлөгөө өгсөн салбарын судлаачдад талархал илэрхийлье.

Ном зүй

1. М.Алтанбагана, (2022). "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн онолын үндэс, нэгдсэн аргазүй, аргачлалыг шинэчлэн боловсруулах" суурь судалгааны төслийн тайлан," Улаанбаатар
2. Д.Базаргүр, (2007). Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм, эдийн засгийн газарзүйн тандах судалгаа, Улаанбаатар: Admon printing,
3. В.Батцэнгэл (Ред), (2021). Хүмүүний газарзүй, Улаанбаатар: МУИС, Хэвлэлийн газар
4. Б.Гунгаадаш, О.Сүхбаатар, М.Баянтөр, (1971). "БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд", Улсын хэвлэлийн газар
5. БШУЯ, (2023). "Бага, дунд боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээ"
6. Б.Гунгаадаш, (1986). "БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн газарзүй" Улаанбаатар
7. Завхан аймгийн Статистикийн хэлтэс, (2021). "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын Завхан аймгийн нэгдсэн дүн," Улаанбаатар
8. Монгол Улсын Их Хурал, (2023). "Зөвлөлдөж шийдье" улсын хэмжээний зөвлөлдөх санал, асуулгын асуулгын лавлагаа, танилцуулга," Улаанбаатар
9. Монгол Улсын Их Хурал, (1992). Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн ордон, Улаанбаатар
10. Монгол Улсын Их Хурал, (2002). Монгол Улсын бага, дунд боловсролын тухай хууль.
11. Б.Нарантулга (2018) "Монголын нийгэм дэхь шилжих хөдөлгөөн", Admon printing, Улаанбаатар
12. Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, (2021). "Монгол Улсын хүн амын шилжилт хөдөлгөөн ба хөдөлмөр эрхлэлт," Улаанбаатар
13. Ц.Отгонхүү, С.Энх-Амгалан, М.Баяржаргал (2022). "Монгол орны хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд," *Монголын хүн амын сэтгүүл*, vol. 32, pp. 21-32.
14. Ц.Отгонхүү, М.Алтанбагана, (2023). “Завхан аймгийн хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөн” эрдэм шинжилгээний илтгэл, Шинжлэх ухаан, технологийг орон нутагт түгээн дэлгэрүүлэе аян, Улиастай хот
15. Ж.Оюунгэрэл, (2005). "Нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол улсын хүн амын шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд" докторын диссертаци, Улаанбаатар
16. ҮСХ, (2021). "Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2020," Улаанбаатар
17. ҮСХ, (2020). "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн," Улаанбаатар
18. ҮСХ, (2013). "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал," Улаанбаатар
19. О.Сүхбаатар, (1973). "БНМАУ-ын хүн амын шилжих хөдөлгөөн", Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр
20. ХАССТ, (2001). "Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа,"
21. ХАССТ, (2004). "Улаанбаатар хотын хүн амын ядуурал ба шилжих хөдөлгөөн," Улаанбаатар
22. ХАССТ, (2006). "Хүн ам зүйн үндсэн асуудлууд" сурах бичиг, Улаанбаатар
23. ХАССТ, (2009). "Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар," Бит пресс, Улаанбаатар
24. ХАССТ, (2018). "Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа," Улаанбаатар
25. С.Энх-Амгалан, Д.Хишигдорж, Ц.Отгонхүү, Г.Урантамир, Б.Нацагсүрэн, П.Цэнханд. (2021). "Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа," Улаанбаатар
26. С.Энх-Амгалан, Д.Доржготов, Ж.Оюунгэрэл. (2012). “Газарзүйн шинжлэх ухаан Монголд” Газарзүйн хүрээлэнгийн 50 жилийн ойд зориулсан бүтээл, Улаанбаатар
27. Alгаа, S. (2020). Internal migration in Mongolia. *Internal Migration in the Countries of Asia: A Cross-national Comparison*, 77-91.
28. Ahearn, A. (2018). Herders and hazards: covariate dzud risk and the cost of risk management strategies in a Mongolian subdistrict. *Natural Hazards*, 92(Suppl 1), 165-181.

29. Fernandez-Gimenez, M. E., Batkhishig, B., & Batbuyan, B. (2012). Cross-boundary and cross-level dynamics increase vulnerability to severe winter disasters (dzud) in Mongolia. *Global Environmental Change*, 22(4), 836-851.
30. Government of Mongolia. (2023) Mongolia voluntary national review: Implementation of the Sustainable Development Goals, Ulaanbaatar
31. Lee, E. S. (1966). A theory of migration. *Demography*, 3, 47-57.
32. Nandintsetseg, B., Shinoda, M., & Erdenetsetseg, B. (2018). Contributions of multiple climate hazards and overgrazing to the 2009/2010 winter disaster in Mongolia. *Natural Hazards*, 92, 109-126.
33. Röckert, J., & Kraehnert, K. (2022). Extreme weather events and internal migration: Evidence from Mongolia. *Economics of Disasters and Climate Change*, 6(1), 95-128.
34. Sternberg, T. (2010). Unravelling Mongolia's extreme winter disaster of 2010. *Nomadic Peoples*, 14(1), 72-86.
35. Schoening, S. (2020). Lessons from internal climate migration in Mongolia. *Forced Migration Review*, (64).
36. Togtokh, C., & Gaffney, O. (2010). Human sustainable development index. *Our World*, 2.
37. Xu, Y., Zhang, Y., & Chen, J. (2021). Migration under economic transition and changing climate in Mongolia. *Journal of Arid Environments*, 185, 104333.